



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/314

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "А" заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг орон нутагт зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Г.Гончигсүрэн - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Ц.Пүрэвсүрэн – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Гэрэлтуяа - Аймгийн мэргэжлийн хяналтын газрын Мал үржлийн хяналтын улсын байцаагч

Г.Бат-Өлзий -Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

С.Шүрхүү - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

Ж.Болормаа -Хүнс, хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч

Нарийн бичгийн

дарга: Б.Атарсайхан - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

02 01539

Zax A/314 Ch

2. Үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг Малын үржил, бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын удирдамжийн дагуу зохион байгуулсугай.

3. Үржлийн малд үзлэг ангилалт явуулсан дүн мэдээ цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2019 оны 10 дугаар сард багтаан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Гончигсүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН